



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/651

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 10/06 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймагт зохион байгуулагдах Өсвөр үеийн үндэсний бөхийн улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох баг тамирчдын замын зардлын дэмжлэгт 900 000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Замын зардлын дэмжлэгт зарцуулагдах 900 000 төгрөг /Есөн зуун мянга /-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 5.17-д тусгагдсан арга хэмжээнээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Даваадорж/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2020 оны
10 дугаар сарын 30 -ны өдрийн А/651
дүгээр захирамжийн хавсралт

ӨСВӨР ҮЕИЙН ҮНДЭСНИЙ БӨХИЙН УЛСЫН АВАРГА
ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНД ОРОЛЦОХ ТАМИРЧДЫН
ДЭМЖЛЭГИЙН ТӨСӨВ

Д/д	Зохион байгуулах арга хэмжээ	Хэмжих нэгж Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Ховд-Улаанбаатар	4	75000	300000
2	Улаанбаатар-Ховд	4	75000	300000
3	Улаанбаатар-Булган	4	25000	100000
4	Булган-Улаанбаатар	4	25000	100000
5	Тэмцээний эрхийн төлбөр	1	100000	100000
	Нийт			900 000

-oOo-